



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/15

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.2, Сангийн сайдын 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолын 04 дүгээр хавсралын 4.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан “Эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж”-ийг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

С.Уранцэцэг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Х.Алтанцэцэг

(Орон нутгийн өмчийн газрын орон нутгийн өмч хариуцсан ахлах мэргэжилтэн)

У.Ариун-Эрдэнэ

(Нэгдсэн эмнэлэгийн дарга)

/Зөвшилцсөнөөр/

Г.Ганболд

(Нэгдсэн эмнэлэгийн ахлах нягтлан бодогч)

/Зөвшилцсөнөөр/

Ж.Баттогтох

(Мехатроник ХХК-ийн төслийн инженер)

Нарийн бичгийн дарга:

Г.Энххишиг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Техник, тоног төхөөрөмжийг холбогдох хууль, тогтоомж, техникийн тодорхойлолтод заагдсан тоо хэмжээ, тавигдсан шаардлагын дагуу шалган хүлээн авч үр дүнг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (С.Уранцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.СОДНОМ